

Хангийн Түүхийн хичээл

ИХ МОНГОЛ УЛС

- ❑ Тэмүжин Хиад боржигин Есүхэй болон түүний их эхнэр Олхунуд Өгэлүн хоёрын ууган хөвгүүн, Хабул хааны гуч болон Онон мөрний Дэлүүн болдог хэмээх газар мэндэлжээ.
- ❑ Есүхэй Татарын баатар Тэмүжин Үгэ хэмээгчийг тулаанд ялж барьж ирэхэд төрсөн тул Тэмүжин буюу Төмөрчин нэрийг өгчээ.




- ❑ Тэмүжинг есөн нас хүрэх үед Өгүлэн, Есүхэйн дундаас Хасар, Хачигун, Тэмүгэ нэрт хөвгүүд хийгээд Тэмүлүн нэрт охин төрсөн байв.
- ❑ Харин Есүхэйн бага эхнэр Сочигэлээс Бэгтэр, Бэлгүтэй хоёр төрсөн байлаа.
- ❑ Есүхэйн сонгосон бэр нь Тэмүжинээс нэг насаар эгч Бөртэ, Хонгирадын Дэй Сэцэний охин байв.

Чингис хааны хөрөг,
Тайваний Үндэсний Хааны Ордон музей

ИХ МОИГОН УНС

ТЭМҮЖИН ХААН ШИРЭЭНИЙ ТӨЛӨӨ



ИХ МОНГОЛ УЛС

Тэмүжин хаан ширээний төлөв



- ❑ Тэмүжин өсөж томрохын хэрээр өрсөлдөгчид нь түүнийг дарахаар удаа дараа оролдож байлаа. Тайчууд аймгийн толгойлогчид “Хурганы үс гуужив, төлөгний үс төлжив” хэмээн довтлон ирж, Тэмүжинг олзлов.
- ❑ 1179 онд мэргидүүд Тэмүжиний хүрээг довтлон Бөртэ үжин, Сочигэл эх нарыг олзлон одов.
- ❑ Тэмүжинд мэргидийг даруй дайлж хариу авах хангалттай хүч байсангүй. Тиймээс эцгийн анд Тоорил болон өөрийн анд Жамуха нараас тусламж хүсэв.
- ❑ Буур хээр хэмээх газар болсон тулалдаан бол түүний хийсэн анхны хатгалдаан, анхны ялалт байв.

ИХ МОНГОЛ УЛС


Тэмүжин хаан ширээний төлөө



- ❑ 1189 онд 27 насанд нь Хар зүрхний Хөх нуурт Тэмүжинг Чингис хаан хэмээн нэрийдэж Хамаг Монголын эзэн хан болгожээ.
- ❑ Улсын эзэнд өргөмжлөгдөхөөс өмнө Тэмүжин хаан суудлыг ахмад үе болох Хабул, Хотула хаадын үр сад авга нартаа дараалан найр тавьж санал болгосон боловч тэд хүлээн авсангүй, харин амь насаараа тангараг тавин үнэнчээр дагахаа илэрхийлжээ.

ИХ МОНГОЛ УЛС

Тэмүжин хаан ширээний төлөв




ИХ МОНГОЛ УЛС

Төрийн байгуулал

Аравтын тогтолцоо: аравт, зуут, мянгат, түмт нэгжид зохион байгуулж, нэгж болгон даргачтай болов.

Хэшигтний тогтолцоо: Элит цэргийн анги. Эндээс Их Монгол Улсын цэргийн нэрт жанжид сургагдан боловсорч байв.

Их засаг: Чингисийн тогтоосон засаг хуулийг түүнийг залгамжлагчид өөр өөрсдийнхөөрөө засварлан нэмж өөрчилсөөр байжээ.



Их заргач: Шихихутагийг Их заргачаар томилсон. “Айлгүй үнэнээ хэл”

Их хуралдай: Хаан, их хатад, хан хөвгүүд, алтан ургийн гишүүн, төрийн сайд түшээд, цэргийн жанжид оролцдог байжээ.

Го ван: Төр улсын үйл хэргийг удирдан явуулах, нийт ноёдыг даргалах үүрэгтэй.

ИХ МОНГОЛ УЛС

Төрийн Байгуулал

- ❑ Алтан ургийн гишүүд, гавьяатан сайд нар улсын чухал хэргийг зөвлөн , хэлэлцэх асуудлуудыг тодорхойлох үүрэг бүхий *Их эе* хэмээх байгууллага байв.
- ❑ Их хуралдай хуралдуулах, хаан өргөмжлөх, аян дайнд мордох зэрэг төрийн чухал үйл хэргийг эхлүүлэх өлзийтэй сайн өдрийг сонгон, цаг, зүг чигийг зааж өгөх үүрэг бүхий алтан тушаалтныг *төрийн бэхи* хэмээнэ.
- ❑ Их Монгол Улсыг байгуулахад онцгой гавьяа байгуулсан Боорчи, Зэлмэ, Сорхон шар зэрэг хүмүүсийг *дархан* болгожээ.
- ❑ Цэргийн жанждаас Боорчи, Мухулай, Борохул, Чулуун нарыг “дөрвөн хүлэг”, Хубилай, Зэлмэ, Зэв, Сүбээдэй нарыг “дөрвөн нохой” хэмээн онцгойлон үздэг байв.

ИХ МОНГОЛ УЛС


Нийгмийн Бүтэц

Ихэс язгууртан

Хаан

Алтан ургийнхан

Түмт, мянгат,
зуутын дарга нар



Энгийн ард

Мянгатын: цэрэгт мордох,
алба татвар

Харьяат иргэд

ИХ МОНГОЛ УЛС

Соёл



- ❑ Монголын уран бичлэгийн калиграфийн монгол бичгээр бичиж үлдээсэн хамгийн эртний дурсгалын нэг нь **Чингисийн чулууны бичиг** хэмээн алдаршсан, эдүгээ Санкт-Петербургийн Эрмитажид хадгалагдаж буй гэрэлт хөшөө чулууны бичээс юм.
- ❑ Монголчууд Хорезм улсыг байлдан дагуулсан аян дайнаас буцах замдаа Эрчис мөрний эрэгт зусаж Их Монгол улсын ноёдын хуралдай хуралдуулан өргөн дэлгэр хурим найр хийсэн аж. Хуралдайн үеэр Есүнгэ /1190-1270/ мэргэн 335 алд газарт бай харван оножээ. Түүний энэхүү хосгүй мэргэн харвасан алдрыг нь дуурсган хөшөө дурсгал босгосон нь хожмоо “Чингисийн чулууны бичиг” хэмээн алдаршсан билээ. Ингэж нэрлэх болсон учир гэвэл бичээсийн тэргүүнд Чингис хааны нэрийг мөр тэтгэн бичсэн байдагтай холбоотой.

ИХ МОНГОЛ УЛС

Чингис хааны байлдан дагуулал

Чингис хаан урьдаас бодож төлөвлөсний дараа шинээр байгуулсан улсынхаа тэлэлтийг Тангуд буюу Хашин улсаар эхлүүлэхээр шийджээ. Яагаад ?

ШАЛТГААН ТОРГОНЫ ЗАМ


АМЖИЛТ ГАРГАХ МАГАДЛАЛТАЙ

АЛТАН УЛСЫГ ГЕОПОЛИТИКИЙН ХУВЬД ГАНЦААРДУУЛАХ

ТАНГУД УЛСЫН ХААНЫ ОРДОН ХЭРЭЙДИЙН ОЛОН
УДИРДАГЧИД, ЯЛАНГУЯА СЭНГҮМИЙГ ОРОГНУУЛЖ БАЙВ.

ИХ МОНГОЛ УЛС

Чингис хааны байлдан дагуулал



<https://mn.wikipedia.org/wiki/%D0%A2%D0%B0%D0%BD%D0%B3%D1%83%D0%B4%D1%83%D0%BB%D1%81>

- ❑ 1205, 1207 онд Тангуд руу бага хэмжээний довтолгоо хийж тухайн улсын газарзүй, эдийн засаг, нийгмийн байдлыг тагнан туршсаны дараа 1209 онд их хэмжээний цэрэгтэй довтолов.
- ❑ Нийслэл Яргай хот эзлэгдсэний дараа Тангуд жил бүр атан тэмээ, хоргой торго, шонхор шувуугаар алба барихаар болов.
- ❑ Тангудыг эрхшээлдээ оруулалгүй дагуул улс болгосон тул тэд цэргийн хүч нийлүүлэх үүрэг хүлээжээ.

ИХ МОНГОЛ УЛС

Чингис хааны Байлдан дагуулал

Хашин улсын Бурхан (эзэн) дагаар орж, "баруун гар чинь болж хүчээ өгье" гэж Чага нэртэй охиноо Чингис хаанд авчирч өгөв. Бас Бурхан өгүүлрүүн: "Чингис хааны нэр алдрыг сонсож айн биширч байв бид. Одоо Сүлдэт биеийг чинь хүрч ирсэнд сүрдэн их айж байна. Айн сүрдсэн манай тангуд улс баруун гар чинь болж хүчээ өгье. Хүчээ өгөхдөө бид:

"Байсан газартаа байран нутагладаг
Шавар хотдоо шавалдан суудаг хүмүүс тул
Хурдан аянд түргэн хөдөлж чадахгүй
Хурц дайнд даруй мордож амжихгүй
Хаан Чингис соёрхвол
Хамаг Тангуд улс
Өндөр дэрсний нөмөрт өсгөсөн олон тэмээгээ
Өргөл болгож тусалъя
Өөрийн гараар нэхсэн өрмөг бөс эдээ бэлэг
болгож өгье
Арга чадлаар сургасан анч шонхор шувуудын
Аль сайныг хүргээ" гэдгээ өчье гэжээ.

Монголын нууц товчоо

ИЖ МОНГОЛ УЛС

Чингис хааны байлдан дагуулал



Алтан улс руу довтлох болсон шалтгаан юу байв.

- ☐ Алтан улсын сул дорой байлгах бодлого
- ☐ Монголын удирдагчид тамлагдан хороогдсон
- ☐ Алтан улсад алба барьсаар байсан
- ☐ Дотооддоо хямралтай байсан.
- ☐ Торгоны замын зангилаа цэг болж байсан.

1211 онд Чингис хаан Алтан улсын нутаг руу цэргээ хоёр жигүүрээр оруулсан. Зүүн жигүүрийг хаан өөрөө, баруун жигүүрийг Зэв жанжин удирдахаар болжээ.

Алтан улсын хаан хэлэлцээр хийхийг хүсэж монголчууд довтолгоогоо зогсоов.

1214 онд Алтан улс нийслэлээ ухраасан. Энэ арга хэмжээг монголчууд хэлэлцээрийг зөрчсөн явдал гэж үзэж Жүндү хотыг дахин эзлэв.

ИХ МОНГОЛ УЛС

Чингис хааны байлдан дагуулал



Хорезмын Отрар хотын захирагч Инал хан эзэн султаны зөвшөөрлөөр гэрээ хэлэлцээрийн дагуу Чингисийн илгээсэн исламын шашинт худалдаачдыг дээрэмдэж харгислаж алжээ. Үүнийг сонссон Чингис хаан элч илгээж, Отрар хотын захирагчийг шийтгэн цаазалж, хоёр орны найрамдалт харилцааг сэргээн хохирсон бараа таваарыг гаргаж эргүүлэн илгээхийг мэдэгдэв. Үүний хариуд султан элч нарыг хороожээ.

1219 онд 80000 шилмэл монгол цэрэг, 60000 янз бүрийн угсаатнуудаас бүрдсэн цэрэг, 15000 тусгай цэргийн хүч, нийт 150000 гаруй цэргийн хүчээр довтолгоог эхлүүлжээ.

ИХ МОНГОЛ УЛС

Чингис хааны байлдан дагуулал



Хорезмын Отрар хотын захирагч Инал хан эзэн султаны зөвшөөрлөөр гэрээ хэлэлцээрийн дагуу Чингисийн илгээсэн исламын шашинт худалдаачдыг дээрэмдэж харгислаж алжээ. Үүнийг сонссон Чингис хаан элч илгээж, Отрар хотын захирагчийг шийтгэн цаазалж, хоёр орны найрамдалт харилцааг сэргээн хохирсон бараа таваарыг гаргаж эргүүлэн илгээхийг мэдэгдэв. Үүний хариуд султан элч нарыг хороожээ.

1219 онд 80000 шилмэл монгол цэрэг, 60000 янз бүрийн угсаатнуудаас бүрдсэн цэрэг, 15000 тусгай цэргийн хүч, нийт 150000 гаруй цэргийн хүчээр довтолгоог эхлүүлжээ.

Чингис хааны байлдан дагуулал

5

СУРВАЛЖ

Ата Малик Жувейнигийн “Ертөнцийг байлдан дагуулагчийн түүх”-ээс.

“Чингис хаан Нур хотод хүрэлцэн ирэх үед ард олон гудманд жагсан угтаж авав. Үнэт бэлэг ч олныг өргөн барив. Чингис хаан хотын хүн ардын найрсаг зангийн хариуд адил хэмжээний хайр соёрхол хүртээсний дараа Хорезм султаны Нур хотоос жилд татдаг асан татварын хэмжээг асуув. “1500 динар” гэх хариулт сонсоод Чингис хаан мөн адил хэмжээний татвар төлөхийг зарлигдаад, ямар ч дээрэм халдлага үл үйлдэхийг цэргүүддээ тушаав”. (Нур хот-Бухарын ойролцоо оршино. Өнөөгийн Узбекистанд буй.)

СУРВАЛЖИЙН
МЭДЭЭ



АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА